

МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛЫН ТАЛААРХИ ПРОФЕССОР Ж. ЦЭВЭЭНИЙ БОДРОЛ

МУИС, ОУХС-ийн ахлах багш
Д. Уламбаяр

Улс үндсээ өөд татах, хүн ардаа соён гэгээрүүлэхийн төлөө нэгэн үзүүрт сэтгэл барьж тэмцсэн манай улс төр, шинжлэх ухааны томоохон зүтгэлтнүүдийн нэг нь нэрт соён гэгээрүүлэгч, хүнлэг энэрэнгүй үзэлтэн, доктор, профессор Жамсрангийн Цэвээн гуай юм. Ж. Цэвээн гуайн нэр аанай л "барууны үзэл сурталч", "пан монголизмыг номлогч", "баяжигтун лоозонг санаачлан талархагч", "Марксын сургаалыг буддын суртал лугаа адилтгагч"-ийн дүр төрх болж олны сэтгэлд бууж ирсэн билээ. Гэвч түүхэн зүтгэлтнүүдийн үйл ажиллагааг тун ч өрөөсгөлөөр тайлбарлаж бичиж байсан үе нэгэнт өнгөрч түүхэн үнэнийг сэргээх сайн цаг ирсэн билээ.

Шарайт овогт Жамсрангийн Цэвээн нь /1881-1940/ Өвөр Байгалын Агийн аймагт 1881 онд төрсөн. Тэрбээр Чита хотын 3 жилийн сургууль, Санкт-Петербургийн гимнази, Эрхүү хотын багш нарын семинар, Петербургийн их сургуулийн Дорно дахины факультетыг тус тус төгссөн. 1907-1908 оны зун хүртэл Санкт-Петербургийн их сургуульд монгол хэлний туслах багшаар ажиллаж байв. 1909-1910 онд Өвөрлөгч нутагт шинжилгээний ажлаар явсан. 1911 оны эцсээр Монгол оронд ирж Хаант Монгол Улсын Гадаад Явдлын Яамны соёл эрхэлсэн туслах түшмэл, ГЯЯ-ны дэргэдэх сургуулийн багш, дараа нь "Шинэ толь", "Нийслэл хүрээний сонин бичиг" сэтгүүлийн эрхлэгч, 1913 оны сүүлчээр Хаант Монгол Улсын өрөнхий сайд, Сайн ноён хан Намнансүрэн, ГЯЯ-ны дэд сайд гүн Б.Цэрэндоржийн хамт Санкт-Петербургт очсон. 1915 оны Хиагтын гурван улсын хэлэлцээрт эксперт, орчуулагчаар оролцсон. 1917 оны 2 дугаар сарын Оросын Хөрөнгөтний ардчилсан хувьсгалын дараа Буриад Монголдоо буцаж Өвөр Байгалын нийгэм улс төрийн ажиллагаанд идэвхтэй оролцож 1917 оны 11 дүгээр сард хуралдсан бүх Буриадын 4 дүгээр их хурлаас Төвийн Үндэсний хороонд даргаар сонгогдон 1918 оны 3 дугаар сарын 28 хүртэл ажилласан. 1918 оны 3 дугаар сарын 24-нөөс 6 дугаар сарын 5-нд болсон Өвөр Байгалын Буриад Казакийн Ажилчин-Тариачны төлөөлөгчдийн 2 дугаар их хуралд идэвхтэй оролцож Буриадын секцээс зөвлөлүүдийн Мужийн Гүйцэтгэх хорооны гишүүнээр сонгогдож, Үндэсний асуудал эрхэлсэн комиссараар томилогдсон. 1919-1920 онд Эрхүүгийн их сургуульд монгол хэлний багш, 1920 оны зунаас Монголын хувьсгалын хэрэгт зүтгэж МАН-ын анхдугаар их хуралд оролцож намд гишүүнээр элссэн, хувьсгалын ялалтын дараа Дотоод яамны дэд сайд /1921-1923/, 1923 оноос Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1924 онд Ардыг Гэгээрүүлэх яам байгуулахад зөвлөх түшмэл, мөн эдийн засгийн зөвлөлийн боловсронгуй гишүүн, Монгол банкны зөвлөлийн гишүүн, "Жизнь Буриаты" сэтгүүлийн редакцын коллегийн гишүүн, Оюутны сургуулийн багш зэрэг ажил хийж байв. 1923-1924 онд Намын Төв Хорооны тэргүүлэгч гишүүн, 1924-1925 онд Намын Төв хорооны гишүүн, 1925-1928 онд Намын ХБТК-ны орлогч, тэргүүлэгч, 1924-1925 онд Улсын Бага Хурлын гишүүнээр сонгогдож байв. 1929 онд явагдсан намын 2 дугаар цэвэрлэгээгээр "баруунтан" хэмээгдэж намаас хөөгджээ. 1928-1930 онд Судар Бичгийн Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1930-1932 онд Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн эрдэмтэн гишүүн, 1933-1937 онд Ленинград дахь ЗХУ-ын ШУА-ын Дорно дахиныг судлах хүрээлэнд эрдэм шинжилгээний ажил хийж байв. 1919 онд Эрхүүгийн их сургуулийн профессор, 1923 онд Буриадын Шинжлэх ухааны хүрээлэнгийн гишүүн, 1936 онд хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг хүртэж удалгүй ЗХУ-ын ШУА-ын сурвалжлагч гишүүнээр сонгогджээ. 1937 оны 8 дугаар сард улс төрийн хилс хэрэгт баривчлагдаж 1940 онд хэлмэгдсэн. 1956 онд цагаатгасан байна.

20-иод оныг тус орны улс төр, эдийн засаг, оюуны амьдралд эргэлтийн шинжтэй гэж хэлж болохуйц, ингэхлээрээ нарийн төвөгтэй, үүгээрээ манай шинэхэн түүхийн нэн сонирхолтой үе гэж хэлж болохоор юм. Учир нь урьд өмнө шийдвэрлэж байгаагүй олон чухал асуудлууд энэ

үед цоо шинээр дэвшигдэн гарч иржээ. Улс төрийн зүтгэлтнүүд, олон түмэн тэдгээр үзэгдэл, үйл явцыг өөр өөрийнхөөрөө үнэлж, цэгнэж, янз бүрээр хандаж байв. Шинэ цагийн мэдлэг боловсрол, туршлагатай боловсон хүчин ч ихээхэн дутагдаж, байдлыг улам төвөгтэй болгож байсан нь ойлгомжтой. Тиймээс алдаж онох нь их байлаа.

ЗХУ-д өрнөж эхлээд байсан эдийн засгийн шинэ бодлого ч манай оронд нааштай сэтгэгдэл төрүүлсэн боловч манай нам, төрийн удирдлагын бие даасан бодлого, үйл ажиллагааг Коминтерн захиргаадан чиглүүлж ихээхэн даралт, шахалт үзүүлж байлаа. Нөгөө талд Алс Дорнодод олон улсын байдал ч таатай биш байсан юм.

Түүхэн ийм нөхцөлд улс орны тусгаар тогтнолыг бататгах, нийгэм журам тийш хөгжүүлэх янз бүрийн хувилбаруудыг улс төрийн зүтгэлтнүүд шаргуу эрэн хайж эхэлжээ. Намын Төв Хорооны тэргүүлэгч гишүүн, профессор Ж.Цэвээний баримтлал нь тэрхүү эрэл хайгуулын тодорхой нэгэн илрэл байв.

Ж.Цэвээн бол Орос улсын Санкт-Петербург хотноо дээд боловсролыг олсон томоохон эрдэмтэн бөгөөд МАН-ыг байгуулах, түүний мөрийн хөтөлбөрийг боловсруулах болон ардын хувьсгалын үйлсэд идэвхийлэн оролцож явсан гавьяатай хүн билээ. Хувьсгалын эхний үед шинэ цагийн мэргэжил мэдлэг бүхий боловсон хүчин нэн ховор байсан цагт Ж.Цэвээн эрдэм боловсролтойнхоо хувьд төдийгүй, хариуцлагатай алба хашиж байсны хувьд нам, улсын зүтгэлтэн нарт үзэл санааны талаар нөлөөтэй байлаа.

Профессор Ж.Цэвээн Монгол орны нийгмийн хөгжлийн ирээдүйн төлвийг бодитойгоор төсөөлж байжээ. Тэрээр нүүдэлчин ард түмний нийгэм журамд шилжих зам марксизм-ленинизмийг үндэслэгчдийн зааснаас нэлээд онцлог ялгаатай гэж үзээд, "Төв Азийн газар оронд явуулвал зохих ардын нийгэм журмын ёс"¹ гэсэн баримтлал боловсруулж, түүнийгээ Монголын нийгмийн хөгжлийн гол мөрийн хөтөлбөр болгох санал дэвшүүлсэн байна.

1. Нийгэм - улс төр, үндэсний асуудал

Шинэ тулгар хөгжиж буй Монгол улсын дотоод, гадаад байдлыг хангах тэргүүн зэргийн зорилт бол бүх монгол үндэстнийг нэгтгэн авч хүчирхэг Их Монгол улсыг байгуулах, ингэснээрээ хэнтэй ч эсэргүүцэвч хор аюулыг үзэхгүй хэмээн Ж.Цэвээн үзэж байлаа. Тэр 1924 онд хэлэхдээ "...Монгол улсын тусгаар тогтнон хүмүүжих явдал манай Гадаад Монголын нэгэн хэсэг газрын төдийгөөр бат хүчирхэг болон чадахгүй учир эрхбиш Монгол язгууртан бүхнийг нэгтгэн авч санаа зоригийг нийлүүлэн гүйцэтгэвэл хэнтэй ч эсэргүүцэвч хүчин чадал нь буурай дорой хохирлыг хүлээхэд хүрэхгүй учир намын нэгдүгээр их хуралд Монгол язгууртныг нэгтгэх тухай хэргийг шүүмжлэн хэлэлцэж тогтсон зүйл буй боловч өнөө хүртэл үүсгэн шийдээгүй нь манай улсын бас л нэгэн үндсэн ихээхэн чухал хэрэг хожимдон саатаж, хорыг хүлээж мэдэшгүй тул ... энэ

¹ Заявления Ц.Жамцарано в ЦК МНРП. Ф.1., Т.4., ХН.99

тнүүд, олон
с, цэгнэж, янз
туршлагатай
эгтэй болгож

лого ч манай
нам, төрийн
захиргаадан
өө талд Алс

атгах, нийгэм
н зүтгэлтнүүд
лэгч гишүүн,
ын тодорхой

отноо дээд
байгуулах,
хувьсгалын
сгалын эхний
ховор байсан
ариуцлагатай
нааны талаар

ийн ирээдүйн
ард түмний
ндэслэгчдийн
газар оронд
боловсруулж,
өлбөр болгох

аад байдлыг
нэгтгэн авч
эсэргүүцэвч
онд хэлэхдээ
анай Гадаад
лон чадахгүй
аа зоригийг
буурай дорой
алд Монгол
сон зүйл буй
нэгэн үндсэн
үй тул ... энэ

тухайг шүүмжлэн хэлэлцэж эрх биш гүйцэтгэн явуулахыг ихэд итгэн
горилох бөгөөд эдгээр сануулж илтгэсэн зүйлүүдийг тус тус тайлбарлан
шүүмжилж дутагдсан хожимдсон зэргүүдийг засаж сайжруулах заавар
тогтоолыг гаргаж, Ардын нам ба Ардын засгийн хэргийг үүрд бат нотоор
дэлгэрүүлэхийг ихэд итгэж байна"² гэжээ. Ж.Цэвээн намын анхны
программд "Монгол Ардын Нам эрмэлзэх нь алсдаа Монгол үндэстэн
бүгдээр нийлж нэгэн улс болохыг хүснэ" гэж тусгасан зүйлээ иш үндэс
болгон, нам энэ зорилтыг хэрэгжүүлэхэд их л хойргошиж байна гэж
шүүмжилсэн байна.

Тэр Монгол улс газар нутгийн хувьд харьцангуй том, харин хүн
амын хувьд ихээхэн цөөн, хүн ам ийнхүү сийрэг байгаа нь эрчимтэй
хөгжих бололцоогүй болгож байна. Учир иймийн тул улс орны эдийн
засаг, соёлыг амжилттай хөгжүүлэхэд хүн амыг ядаж хоёр дахин өсгөх
хэрэгтэй гэжээ. Иймд Монгол үндэстний төр улсыг бататгахад юуны өмнө
дотоод Монгол, Буриад, Халимаг зэрэг Төв Азийн газар оронд бутран
тарсан Монгол овогтныг уугуул нутагт нь нүүлгэж ирүүлэх нь зүйд
нийцнэ. Гэхдээ Хувьсгалт Монгол болох Халх нь эдийн засаг, соёл, эрх
зүйн ололт амжилтаараа үлгэр жишээ үзүүлж, бусад Шилийн голийн
Цахар, Улаан цав, Алаша, Эзний голын барга, цаашлаад Төв Азийн Төвд,
Хөх нуур, Синь Цзянь зэрэг газар орныг өөртөө үлгэрлэн татах хэрэгтэй.
Үүнд бас Дорнод гурван чуулганыг /жирэм, жост, зүүд/ сайн дурынх нь
үндсэн дээр БНМАУ-д нүүлгэж ирүүлэх хэрэгтэй юм. Тэгэх аваас Халхын
хүн ам нягтарч, аж ахуйн боломж өсч, соёл боловсрол өрнөн хөгжих аятай
боломж нэгэнт бүрдэх билээ³. Алсдаа ЗХУ-ын дэмжлэгтэйгээр БНМАУ-ыг
тойруулан өмнөд этгээдийн Хөх нуур, Түвд, Хятадын Туркестан, (Синь
Цзянь Д.У), умард этгээдийн Тагна-Тува, бусад Монгол угсаатны
бүрэлдэхүүнтэйгээр Улаанбаатар хотоор төвлөрсөн Төв Азийн Холбоот
Улсыг (федерация) байгуулах нь зохистой. Ийм Холбоот Улсыг байгуулж
чадах ахул Хятад, Орос, Япон зэрэг улсуудын алинд нь ч гишгэгдэхгүй
тусгаар тогтносон⁴, бие даасан улс болж чадах юм гэж үзэж байжээ. Нөгөө
талаар Монгол оронд Ардын хувьсгал ялсны дараа дотоод Монгол,
Буриад Монгол, Тагна-Тувагийн ард түмэн Монгол улсад сайн дураараа
нэгдэх хүсэлтэй байгаагаа нэг биш удаа илэрхийлж байсныг тэрээр иш
үндэс болгосон байна.

Цаашлаад "Төрийн бие даасан байдал, жинхэнэ тусгаар тогтнолыг
олоход зөвхөн ЗСБНХУ-аар хүлээн зөвшөөрөгдөх төдийгүй мөн Хятад
болон бусад гүрнүүдээр хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой билээ. Бид
Хятадын сюзернитет (эзэн эрх Д.У) ч биш, ЗСБНХУ-ын протекторат
(ивээл асрамжийн дор Д.У) ч биш, харин ЗСБНХУ, Хятад зэрэг улсаас
баталсан бөгөөд бусад олон улсаас хүлээн зөвшөөрсөн, ер нь Швейцарь
лугаа адил төвийг сахисан улс байх ёстой⁵", "чухамхүү ийм болж чадах

² МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд УБ., 1966он., 1-р дэвтэр, 34 дэх тал

³ Заявления Ц.Жамцарано в ЦК МНРП. Ф.1., Т.4., ХН.99

⁴ мөн тэнд

⁵ мөн тэнд

аваас Монгол хэмээх хоцрогдсон улс орон амар төвшнөөр соёл боловсролын хөгжлөө хангаж чадна⁶ гэж Жамсрангийн Цэвээн үзжээ.

Өгүүлэн буй үед гадаад байдал нэн төвөгтэй байсныг дээр тэмдэглэсэн билээ. Учир нь 20-иод оноос Японы цэргийн бүлгийнхэн суртал нэвтрүүлгээ хүчтэй болгож түүнийхээ гол баримтлал паназиатизмын (Аугаа Их Азийн) үзэл гэгчийг илэрхий номлох болсон юм. Тэд Монгол-Зөвлөлтийн найрамдлыг гутаан муучилж, монголчууд Оросоос салж цацран мандаж буй Наран улсын ивээл дор Их Монгол улсыг байгуулан, түүндээ Түвдээс Байгал нуур, Шинжаниас (Синь Цзянь) Хянган хүртэл оршиж байгаа бүх Монгол угсаатныг нэгтгэж Чингис хааны улсыг сэргээх паназиатизмын үзлийг дэмжин хөхүүлж байлаа⁷. Үүнийг нь Улаан Орос, Коминтерн Монголд өөрийн нөлөөг тогтооход илэрхий ашиглан сөрөг суртлаа хүчтэй дэвэргээж байлаа. Чухам ийм үед Ж.Цэвээний баримтлалыг намын бусад зүтгэлтэн ойлгоход бүр ч төвөгтэй болгосон нь мэдээж.

Ж.Цэвээний саналыг 1928 онд хуралдсан МАХН-ын VII их хурал эрс няцаасан байна. Коминтерний төлөөлөгч Б.Шмераль их хуралд оролцож үг хэлэхдээ "Японы энэхүү лоозон нь Монголын ард түмний ашиг тусын тулд бус гагцхүү Монголын ард түмнийг өөрийн бодлогыг бүтээх хэрэгт шатрын хүү болгон ашиглахыг эрмэлзсэн хэрэг болно. Энэ бодлогын үндсэн чанар нь Монголын эрх чөлөөг мандуул хэмээсэн бус харин Гуулин, Манжуур, Дотоод Монголын мэт байдалд оруулахыг эрмэлзсэн нь болно⁸" гэж гоёмсоглон тайлбарласан байна. Түүний хэлсэн үгийн далд чанар нь Монголыг өөрийн нөлөөнд байлгаж бамбай улс болгох гэсэн ЗХУ-ын эчнээ бодлоготой шууд холбоотой байсан нь 1929 оны 1 дүгээр сарын 7-нд Коминтернийн Дорно Дахины нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөн дээр хэлсэн үгнээс одоо л бидэнд тодорхой болж байна⁹.

Гэвч Ж.Цэвээн Намын VII их хурал дээр өөрийн байр суурийг өөрчлөөгүй, үзэл бодлоо хамгаалан түүнийгээ тайлбарласан ажээ.

Түүний дээрх саналыг панмонголизмын илрэл гэж хурц шүүмжилж байсан боловч тэр Монгол туургатныг хүчээр нэгтгэх тухай үзэл санааг харин ч шийдвэртэй эсэргүүцэж байжээ. Бүр 1919 онд Японы болон атаман Семёновыхны идэвхтэй явуулгаар Чита хотноо хуралдсан Өвөр Монгол, Барга ноёдын их хурлаар Нармай Монгол улс гэгчийг байгуулж, төр засгийн газрын гадаад явдлын яамны тэргүүн сайдад Ж.Цэвээнийг өргөмжлөн урихад тэрээр очилгүй энэ бодлогыг эсэргүүцсэн нь баримттай юм. Харин Ренчино Элбэгдорж оролцсоныг энд тэмдэглэхэд илүүдэхгүй.

Гадаад бодлогын талаар төвийг сахих баримтлалтай нь холбогдуулан хэлэхэд Ж.Цэвээн бүр хувьсгалын өмнө болон хойно 1922 оноос анхдугаар Үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаж байхдаа Швейцарь улсын үндсэн хууль ба үндсэн хуулийн чанартай актууд, түүхийн болон бусад судалгааны зохиол бүтээлийг нилээд судалж сайхь улсаас авч хэрглэвэл зохих зүйл байгааг

⁶ мөн тэнд

⁷ Г.Дэмид. Гадаад бодлого ба манай зорилтууд УБ., 1933. 14-15 дахь тал

⁸ МАХН-ын VII их хурал. УБ., 1980. 185 дахь тал

⁹ Коминтерн ба Монгол /Баримт бичгийн эмхтгэл/ УБ., 1996. 103 дахь тал

өвшнөөр соёл
вээн үзжээ.
байсныг дээр
йн бүлгийнхэн
л баримтлал
омлох болсон
ж, монголчууд
р Их Монгол
с (Синь Цзянь)
эгтгэж Чингис
үүлж байлаа⁷.
өөг тогтооход
Чухам ийм үед
бүр ч төвөгтэй

Их хурал эрс
уралд оролцож
ий ашиг тусын
г бүтээх хэрэгт
Энэ бодлогын
сэн бус харин
хыг эрмэлзсэн
сэн үгийн далд
с болгох гэсэн
9 оны 1 дүгээр
н дарга нарын
байна⁹.

байр суурийг
н ажээ.
урц шүүмжилж
ай үзэл санааг
Японы болон
уралдсан Өвөр
нийг байгуулж,
д Ж.Цэвээнийг
н нь баримттай
д илүүдэхгүй.
имтлалтай нь
лон хойно 1922
лах комиссын
ндсэн хууль ба
алгааны зохиол
х зүйл байгааг

тэмдэглэж байв. Энэ тухай санаагаа үндсэн хуулийн талаар өөрийн оруулсан 24 зүйлийн саналд ч дурьдаж байжээ¹⁰. Үнэхээр анхдугаар үндсэн хуулийн төсөл боловсруулахад ЗХУ-ын төдийгүй бас Швейцари улсын үндсэн хуулийг үлгэр болгожээ. Энэ тухай Улсын анхдугаар их хуралд тавьсан засгийн газрын илтгэлд тэмдэглэхдээ: "...Европын Швейцарь хэмээх Бүгд Найрамдах Улсын хэдийнээс тогтсоор ирсэн засгийн байдал ба эдүгээгийн Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын тогтсон засгийн байдлыг үлгэр болгон ... улсын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах ба улсын их хурлын чөлөөт цагт Ардын засгийн газрын хуралд хадгалахаар тогтсон болно¹¹" гэжээ. Хамгийн гол нь олон улсаас батлагдсан төвийг сахисан статус нь Швейцарь улсыг дэлхийн I дайны хөнөөлийн гадна үлдээснийг Ж.Цэвээн гүнээ ойлгож байсан нь тодорхой юм. Тиймээс ч Алс Дорнодод олон улсын байдал нэн нарийн төвөгтэй байсан үед улс орны тусгаар тогтнолыг бататгах хоёрдахь хүчин зүйл бол нийгмийн байгууллын ардчилсан шинжийг хадгалж Швейцарь мэт төвийг сахисан байх нь чухал гэж үзэж байжээ. Тэр улс орноо капиталист мөлжлөгийн замаар хөгжүүлэх гэж Швейцари улсыг үлгэр болгох гээгүй нь түүний дэвшүүлсэн баримтлалаас харагдаж байгаа юм.

Ж.Цэвээн сталинизмын нөлөө Коминтерний шугамаар Монгол оронд нэвтэрч байгааг анхнаас нь мэдэрсэн цөөн хүмүүсийн нэг нь байв. Ленинийг нас барснаас хойш тухайн үед нь түүний онцлон анхааруулж байсан Их Оросын дээрэнгүй үзэл бага буурай орнуудтай харилцахад илэрч байлаа. Үүнийг л тэрээр "улаан империализм" гэж онож хэлсэн хэрэг.

2. Эдийн засгийн асуудал

Ж.Цэвээний эдийн засгийн баримтлал нь Монгол орон хоршоолол, улсын капитализмаар дамжин нийгэм журамд шилжих чиглэлтэй байв. Тухайлбал, хувийн аж ахуйтныг хадгалан дэмжих, ядуучуудыг дундчуудын хэмжээнд хүргэх /өөрөөр хэлбэл 100 хүртэл бодтой/, дундчууд болон баячуудыг улам чинээлэг болгох, энэ явцад дунд болон баян чинээлэг аж ахуйтан ажиллах хүчин мөхөстөж ирэхээр өөрсдөө зайлшгүйгээр хоршооллын системд урган орно. Түүхий эд, өргөн хэрэглээний асуудал бүгд хоршоололд хамрагдсан, санхүү, зээлийн систем улсын банкны гарт, албан татварын систем хувийн хөрөнгөлөг этгээдүүдийг хэрэг дээр нь хавчихад чиглэгдсэн учир иймийн тул 200-300, түүнээс дээш бодтой дунд ба баян чинээлэг аж ахуйтнууд хоршоололд зүй

¹⁰ Улсын Их Хурал. УБ., 1924. 1922 онд Үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссийн бүрэлдэхүүнд Шүүх Яамны

сайд Магсархурц, Гадаад яамны дэд сайд Б.Цэрэндорж нарын хамт оролцсон бөгөөд 1924 оны эхээр уг комисс

төслийн эхийг боловсруулж чадаагүй тул шинээр комисс байгуулахад Ж.Цэвээн дахин оржээ.

¹¹ БНМАУ-ын Анхдугаар их хурал. УБ., 1984., 35 дахь тал

*Robert A. Rupen Cyben Zamcaranovic Zamzarano (1880-1940) "Harvard Journal of Asiatic Studies" Vol 19, 1956 №1 p.35

ёсоор хамрагдана гэж тэрээр үзэж байв. Түүнчлэн ой мод, газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүн гаргадаг, мөн түүхий эд боловсруулдаг үйлдвэр, тээвэр, холбоо, барилга, ер нь нийт үйлдвэрийн салбар улсын капитализмд хамрагдсан байх ёстой. Ийнхүү "хувийн болон баян чинээлэг, мөн нударган аж ахуйтан амьдралын явцаар хоршооллын системд урган орохын зэрэгцээ ерөөс Монгол улс ч бүхэлдээ хоршооллын болон улсын капитализмын хамт дэлхийн аж ахуйн системд гарцаагүй багтан орно"¹² гэж үзжээ.

Профессор Ж.Цэвээн МАХН-ын V их хурал дээр "хүний уул зорилгыг ард олны тусад хандуулвал баяжихыг хориглож болохгүй"¹³ хэмээсэн нөхдийн саналыг бүрэн дэмжээд "... манай намын гишүүд өөрийн ажил юугаа боловсронгуй сайтар явуулж бусад ард олныг хоосруулахгүй, нийтдээ тэгш хөрөнгөжихийг хичээх хэрэгтэй. Баяжих гэдэг үгийг ташааран ухаж болохгүй. Олон нийтээр баяжихыг эрмэлзсэн утга бөгөөд бусдыг мөлжиж хөрөнгөжвөөс үл болно. Хэрэв ард түмнээ үгээгүй хоосны туйлд хүргэж, цөөхөн хүн баяжваас эцэстээ улс төр мөхөхийн шалтгаан болно" гэж "Баяжигтун" лоозонгийн утга учрыг тайлбарласан байна. Намын удирдлагад байсан Ц.Дамбадорж, Н.Жадамбаа, Ж.Цэвээн нарын энэ сэдэв нь эцсийн бүлэгт ардын аж ахуйтны ядуу доод, дунд хэсгийн аж амьдралыг дээшлүүлэх гэсэн эдийн засгийн бодол санаа байсан юм.

Түүнчлэн Ж.Цэвээн эдийн засгаа өөд татахын тулд өндөр хөгжилтэй орнуудтай харилцахад зам харилцаа чухал болохыг бүр тэгэхэд мэдэрч, Монгол орныг гадаад их далайд гаргах боломжийн талаар харгалзан үзвэл зохих тодорхой саналыг ч дэвшүүлж байжээ. Тухайлбал, энэ талаар 1907, 1913 онд Хаант Орос Улстай байгуулсан гэрээ хэлэлцээр, бусад түүхийн баримтуудыг иш үндэс болгон сануулж байжээ¹⁴.

Тэр үед нам, төрийн удирдлагад ажиллаж байсан зарим зүтгэлтэн аж ахуйг эдийн засгийн сонирхол дээр хөтлөн явуулах, үндэсний хөрөнгөлөг этгээд, гадаадын капитал, пүүсүүдийг эдийн засгийг хөгжүүлэхэд идэвхтэй ашиглах, капиталист орнуудтай худалдааны хүрээнд хамтран ажиллах, ер нь нийгмийн байгууллын ялгааг үл харгалзан нийт хүн төрөлхтний үнэт зүйлээс суралцах нь чухал ач холбогдолтой гэж үзэж байжээ*. Үүнд бас капиталист орнуудын эдийн засгийн түр тогтворжилтын амжилт нөлөөлсөн нь эргэлзээгүй бизээ. Гэвч "Баяжигтун" хэмээх лоозонгийн эдийн засгийн агуулга түүнийг хэрэгжүүлэхэд гаргасан алдаатай үйл ажиллагаа хоёрыг ялган салгаж задлан шинжилсэнгүй, мөн хэрэгжүүлж болох өөр арга замыг ч олж туршсангүй, бүхэлд нь няцаан буруутгаж тийнхүү "зүүний" адал балмад үйл ажиллагаа газар авч эхэлжээ.

¹² Заявление Ц.Жамцарано...

¹³ МАХН-ын V Их Хурал. УБ., 1981. 37-38 дахь тал

¹⁴ "Шинэ толь" сэтгүүл №13., 1915.

* 20-иод онд МАХН-ын удирдлагад байсан Ц.Дамбадорж, Н.Жадамбаа нар 1926 онд Итали, Герман, Франц улсаар яваад ирсэн болно.

3. Шашин – гүн ухааны асуудал

Түүний ирээдүйн хөгжлийн баримтлал нь бурхны шашны гүн ухаантай нягт уялдаж байлаа. Профессор Ж.Цэвээн бурхны шашныг өөрчлөгдөж байгаа түүхийн шинэ нөхцөлд тохируулан хөгжүүлж, гэхдээ түүнд шинэтгэл хийхийг уриалан, марксизм ленинизм нь буддизмтай харшлахгүй, харин ч буддын сургаал намын сурталд лавтайяа нийцэх тул түүнийг ариунаар мандуулах, түүнд суралцахын чухлыг цохон тэмдэглэж байв. Ж.Цэвээн өөрийн гүн ухааны үзлийг илэрхийлэхдээ: "Аугаа Их Готама* эв хамтын төгс сургаалыг орчлон ертөнцөд хайрлан соёрхжээ. Түүний орчин үеийн ойлголт Готамагийн буддагаас Ленин хүртэл үзэсгэлэнт гүүр тавьж байна... Тухайлбал, чин зоригтой байх ёс, ангийн болон гадаад ялгааг үл харгалзан бие хүний нэр төрийг хүндэтгэх ёс, бодит мэдлэгийг дээдлэх ёс, өөрийн ухамсрын үндсэн дээр бусдыг энэрэн хайрлахуй ёс энэ бүгд нь суут багш нарын гэрээслэлийг хүн төрөлхтний баяр баясгалангийн тасралтгүй солонго болгож байна. Жинхэнэ буддын сургаалыг Ленин яаж үнэлж байсныг бид мэднэ. Бид түүний гэрээслэлийн дагуу Буддын сургаалын үндсүүдийг бүтээн байгуулах болно"¹⁵ гэжээ. Тэр шашны үзэл, буддын сургаал хоёр бол эрс ялгаатай гэж үзэж байв. К.Маркс "шашныг хар тамхины хорт утаа" хэмээсэн нь тусгай учиртай бөгөөд энэ нь зөвхөн христос, лал мэт эзэрхэг суртлын шашинд өгсөн үнэлэлт, иймийн тул манай бурхны сургаалд огт хамаарахгүй. Хэрэв К.Маркст буддын сургаалын талаар арвин материал байсан бол тэрээр сонирхолтой дүгнэлт хийх байсан нь эргэлзээгүй хэмээжээ. "Манай Ардын намаас бурхны сургаалыг ариунаар мандуулах зорилт нь сүм хийдэд сууж ном цаазын ёсоор санваараа ариун сахин явагч жинхэнэ лам хуврагуудыг дотночлон үзэж байгаа хэрэг. Мөн буддын сургаалыг ийнхүү дотночлон үзэж байгаагийн утга учир нь бурхан Шигмуны сургаал номонд хамгийн нарийн учир шалтгааныг үндсээр нь шинжлэн үнэн зөвийг олсон нь маш гүн бөгөөд элдэвчлэн шинжилвэл шалгадаг ухаанд /шинжлэх ухаан Д.У/ үл харшлан харин ч лавтайяа нийцэх тул үнэхээр бишрэн хүндэтгэж дотночлон үзсэн хэрэг болно... Иймийн тул зүй нь бурхан шашныхаа утга чанар, ёс суртлыг аль болохуйц судлан зөвийг бүдүүвчлэн ялгаж чадах болбоос сайн"¹⁶ хэмээн Ж.Цэвээн бичжээ.

Профессор байгаль дэлхийг бурхан бус өөрийн хууль зүйгээр хөгждөг, дэлхий ертөнц хумхийн тоосноос бүрэлдэн тогтсон, өөрөө байнга хувьсан өөрчлөгдөж байдаг, нар дэлхийг тойрдоггүй, дэлхий бөөрөнхий хийгээд нарыг тойрдог гэх зэрэг байгалийн шалтгаант олон үзэгдлийн тухай, хамаг амьтныг энэрч хайрлах, амар амгаланг тогтоох тухай сэдэв санааг эртний буддын гүн ухаанаас олж харсан бөгөөд ингэхлээрээ буддын сургаал Марксын суртал лугаа нийцэж байгаа юм гэж ойлгож байв.

* Н.Бухарин "Эдийн засгийн бодлогыг цаашид үргэлжүүлж 1925 онд "Баяжигтун" лоозонг албан ёсоор гаргаж иржээ.

* Готама-эртний Энэтхэгийн философич, философийн ньяя системийн үндэслэгч

¹⁵ "Основы Буддизма" Уланбатор. 1921. с.1

¹⁶ ХЗЭ ба Буддын шашин. Хувьсгалт Залуучуудын Эвлэл. 1926. №9. 17-18 дахь тал

МАХН-ын VII их хурал шашны талаархи Ж.Цэвээн авгайн байр суурыг аанай л хурц шүүмжилсэн байна. Их хуралд хурлын тэргүүлэгч, төлөөлөгч, дорно дахины гүн ухаан мэдэхгүй европ боловсрол олсон З.Шижээгээс шүүмжлэхдээ: "...Европт Марксын суртал лугаа мөн энэ мэтээр дүрслэн реформизм суртал дэлгэрснийг жишээлбээс Герман улсын Бернштейн гэдэг хүнээс мөн Марксын суртлыг тэрслэн эдүгээ түүний суртал бол олон түмэн үйлдвэрчний цусыг урсгаж, капитал хөрөнгөтний хурц зэвсэг оруулж байгааг хэнээр ч мэдэх тул мөн нөхөр Жамсрановоос энэ мэтээр буддын балар суртлыг Марксын суртал лугаа тэрслүүлэн Монголын ядуу ба дунд ардыг дахин гал усны гашуун аюулд оруулах гэсэн хортой бодлого болов уу хэмээн санана... Нөхөр Жамсрановын суртал бол хэзээ ч Маркс-Лениний суртал лугаа нийцэхгүй буйзаа"¹⁷ гэсэн байна. Гэвч өнгөрсөн түүх, соёлын дэвшилтэт өв сан, буддын гүн ухааны доторхи диалектик санааг шарын шашны бурангуй үзлээс ялган салгаж зааглаж үзсэнгүй аанай л феодалын суртал хэмээн бүхэлд нь эрс няцааж тийнхүү түүх соёлын дэвшилт өв санг устгах, шашин, сүжиг бишрэлийг хооронд нь ноцтой будлиантуулсан уршигт үйл ажиллагааны эх үндэс чухамдаа энэ үеэс тавигдаж эхэлжээ.

Дүгнэлт

Ж.Цэвээний баримтлал нь Ази, Африкийн орнуудад дэлгэрсэн "үндэсний социализмын" олон янз үзэл онолтой олон талаараа нийтлэг байв. Ерөөс Ж.Цэвээний нийгэм журмын тухай үзэл нь "Туравдахь ертанцөд" дэлгэрсэн үндэсний социализмын олон янз үзэл онолын анхны илрэл байсан гэж үзэж болох юм.

Ж.Цэвээн Монгол орныг нийгэм журам тийш дэвшүүлэн хөгжүүлэх зорилтыг ер үгүйсгээгүйгээр барахгүй харин ч онцлогтой шилжих тухай чиглэлийг барьж байжээ. Ингэхдээ хэт үсрэлт хийх нь хөдөлмөрчин олноо хий тамирдуулж ядаргаанд оруулж болзошгүйг анхааруулаад шилжилтийг алгуур аажим хийх учиртайг дурдсан байна. Түүний баримтлал нь үндэсний онцлогийг харгалзан, феодал анги, баян чинээлэг аж ахуйтны хөрөнгийг хураахгүйгээр улс орныг ангийн тэмцэлгүйгээр аажмаар нийгэм журмын ёсонд шилжүүлэх гэснээрээ хүнлэг, энэрэнгүй, ардчилсан үзэл санаанд дөхөж очихоор байгаа юм.

"Үндэсний социализмын" анхны буюу Төв Азийн хувилбар гэж хэлж болохуйц энэхүү баримтлал гарах болсон нь санамсаргүй тохиолдол биш бөгөөд харин дэлхий нийтийн хөгжлийн хандлага, нийгэм-эдийн засгийн бодит өвөрмөц нөхцөлтэй холбоотой үзэл санаа, онолын эх үндэстэй ажээ. Энэ үзэл нь өөрийн орны үндэсний хэлбэр, түүхэн уламжлал ба марксист ленинист сургаалийн нөлөөн дор бүрэлдэн, барууны орнуудаас нэвтэрч агсан хүнлэг энэрэнгүй, ардчилсан /социал-демократ/ үзэл санааны нөлөөг тусгасан, мөн бурхны шашны гүн ухааны уламжлалыг өөртөө гүнзгий агуулсан байна. Иймээс ч дарангуйлан захирах, харгис үзэл сталинизмтай үндсээрээ харш түүнийг хэрэг дээрээ эрс эсэргүүцсэн шинж төрхтэй үзэл

¹⁷ МАХН-ын VII Их Хурал. УБ., 1980, 230 дахь тал

баримтлал байв. Түүний үзэл соён гэгээрүүлэх, народник, гуманизм, үндэсний үзэл, буддизм болон марксизмын үзлийн цомнол шинжтэй байгаа юм. Гэхдээ ерөөс цэврээрээ оршдог хувьсгалт ардчилсан үзэл гэж байдаггүй ажээ. Тэрээр өөрийн үеийн хувьсгалт ардчилсан үзэлтний томоохон төлөөлөгч байжээ. Профессор Ж.Цэвээний нийгэм улс төр, гүн ухааны үзлийг тунгааж үзэхэд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нэрт зүтгэлтэн Хятадын доктор Сунь Ятсен, Энэтхэгийн М.Ганди, Ж.Неру, Египетийн Г.Насер, Индонезийн А.Сухарно, Ганийн К.Нкрума, Конгын П.Лумумба, Гвинейн А.Секу Туре¹⁸ нарын үзэл баримтлал, үйл ажиллагаатай олон талаар ижил төстэй байгаа юмуу гэсэн санаа аяндаа төрж байна.

The Article deals with concept of Prof. Cyben Zamcarano, prominent political figure, educator and scholar who proposed his own idea about specifics of socialism in Central Asia. It opposed to concepts of marxist – leninist theory regarding transition of nomadic nation to socialism which was imposed by the Soviet Russia and ComIntern.

Prof. Cyben Zamcarano was educated in St. Petersburg he understood that future development of Mongolian society has its uniqueness hence he suggested entire program of social development of Mongolia.

¹⁸ Е.С. Троицкий. Немарксистские концепции социализма и борьба за общественный прогресс в странах Азии и Африки. М., 1976, с.35